БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 30 өдөр Дугаар 19 Улаанбаатар хот

"Баганууурын дулааны станц" ТӨХК-ийн
ажиллагсдад орон сууцны дэмжлэг үзүүлэх
журмыг шинэчлэн батлах тухай

"Компанийн тухай" хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дэх заалт, "Баганууурын дулааны станц" ТӨХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.14 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 07 дугээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Баганууурын дулааны станц" ТӨХК-ийн "Ажиллагсдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг компанийн гүйцэтгэх захирал (Н.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Г.ТӨЙРУУЛЬ

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТУС1174 Я 2688794

“Багануурын дулааны станц” ТӨХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 7 дугаар сарын
30 өдрийн 19 дугаар тогтоолын 2 хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ТӨХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТУС1174Д 2988794

АЖИЛЛАГСДАД ОРОН СУУЦНЫ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Багануурын дулааны станц” ТӨХК-д ажиллаж байгаа ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Орон сууцны дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ тэгш, шударга хандах, ил тод байх зарчмыг баримтална.

1.3.Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.

Хоёр. Хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах

2.1.Ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлэх хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1.Ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлэх зориулалтаар компанийн бизнес төлөвлөгөөнд тусгаж баталсан хөрөнгө;

2.1.2.Тарифт тусгасан хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардал;

2.1.3.Төлбөртэй ажил үйлчилгээнээс олох орлого;

2.1.4.Компанийн хуримтлагдсан ашиг;

2.1.5.Гадаад, дотоодын байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгө;

2.1.6 Бусад хууль, журмын дагуу олгосон хөрөнгийн эх үүсвэр.

2.2.Орон сууцны дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүр төлөвлөж, төсөвт тусгах ажлыг компанийн Гүйцэтгэх захирал хариуцан гүйцэтгэнэ.

Гурав.Орон сууцны дэмжлэгийн төрөл, хэмжээ

3.1.Ажилтан дараах төрлийн дэмжлэгээс аль нэгийг сонгон хүсэлт гаргана.

3.1.1.анх удаа орон сууц худалдан авах;

3.1.2.орон сууцны нөхцөл сайжруулах;

3.1.3.хувийн орон сууц барих;

3.1.4.орон сууцны зээл төлөх.

3.2.Орон сууцны дэмжлэгийн нийт хэмжээ 20.0 /хорь/ хүртэл сая төгрөг байна.

Дөрөв.Хүсэлт гаргах, хүлээн авах, бүртгэх

4.1.Дараах шаардлагыг хангасан ажилтан хүсэлт /цаашид "Хүсэлт гаргагч" гэх/ гаргана.

4.1.1.Компанид тасралтгүй хоёроос доошгүй жил ажилласан байна.

4.1.2.Хүсэлт гаргагч, компанид ажилладаг түүний эхнэр, нөхөр нь орон сууцны дэмжлэг аваагүй;

4.1.3.Сүүлийн 1 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын шийтгэл хүлээгээгүй.

4.2.Хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлж, компанийн Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ:

4.2.1.үндэслэл бүхий хүсэлт;

4.2.2.орон сууцны зээлийн гэрээ хүсэлт гаргагчийн нэр дээр байгааг нотлох баримт бичиг /зээлийн гэрээ, мөнгөн гүйлгээний баримт/;

4.2.4.хүсэлт гаргагчийн болон гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.2.5.өрхийн бусад орлогыг тодорхойлох баримт бичиг /гэр бүлийн бусад гишүүдийн бизнесийн, түрээсийн, ажил үйлчилгээний гэх мэт/;

4.2.6.үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай лавлагаа;

4.2.7.иргэнээс орон сууц худалдан авч байгаа тохиолдолд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээний хуулбар;

4.2.8.оршин суугаа газрын ам бүлийн тодорхойлолт.

4.2.9. Хувийн орон сууц /байшин/ барьсан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай лавлагаа, газар эзэмших өмчлөх эрхийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

4.3.Хүсэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор энэ журмын 4.2-т заасны дагуу хүлээн авна.

4.4.Хүсэлтийг хүлээн авах, бүртгэх ажиллагааг компанийн Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хариуцан гүйцэтгэнэ.

4.5.Хүсэлт гаргагч ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн, халагдсан, огцорсон тохиолдолд орон сууцны дэмжлэг олгохгүй.

Тав.Орон сууцны дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах, түүнийг олгох

5.1.Энэ журмын 4.1-д заасан орон сууцны дэмжлэг хүссэн хүсэлтийг шийдвэрлэхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ:

5.1.1.орон сууцны нөхцөл, эм бүлийн бэйдал, өрхийн орлого;

5.1.2.мэргэжлийн үйл ажиллагааны түвшин, ажлын гүйцэтгэл, үр дүн;

5.1.3.тогтвор суурьшилтай ажилласан байдал;

5.1.4.өмнө нь орон сууцны дэмжлэг авсан эсэх.

5.2.Гэнэтийн бүхий давагдашгүй хүчин зүйлд өртөж амьдралын нөхцөл эрс доройтсон тохиолдолд орон сууцны дэмжлэгийг шийдвэрлэхэд энэ журамд заасан нөхцөл, шаардлагыг харгалзан үзэхгүй байж болно.

5.3.Компанийн хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 4.1, 4.2-т заасан шаардлага хангасан хүсэлт гаргагчийн баримт бичиг, нөхцөл байдлыг нягтлан шалгаж, дэмжлэг олгох эсэх тухай саналыг боловсруулна. Шаардлагатай гэж үзвэл хүсэлт гаргагчийн амьдарч буй ахуй, нөхцөлтэй танилцаж, санал боловсруулах ажлын хэсгийг компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулж болно.

5.4.Орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор энэ журмын 5.3-т заасан саналыг боловсруулан компанийн "Захирлын зөвлөл"-ийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.5.Захирлын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн компанийн Гүйцэтгэх захирал тушаал гаргана.

5.6.Энэ журмын 5.5-д заасан шийдвэр гарснаар компанийн Төсөв, санхүүгийн асуудал хариуцсан нэгж хүсэлт гаргагчид дэмжлэгийг дараах байдлаар олгоно:

5.6.1.зээл олгосон эсхүл зээл олгохоор шийдвэрлэсэн банкны дансанд шилжүүлэх;

5.6.2.орон сууцны нөхцөл сайжруулахтай холбоотой зээл болон иргэнээс орон сууц худалдан авч байгаа тохиолдолд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн төлбөр авагчийн дансанд шилжүүлэх.

5.7.Энэ журмын 5.3-т заасан нөхцөлд орон сууцны дэмжлэгийн мөнгийг хүсэлт гаргагчийн дансанд шилжүүлж болно.

5.8.Орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэр гарснаар орон сууцны дэмжлэг үзүүлсэн нэгдсэн судалгаанд бүртгэнэ.

Зургаа. Бусад

6.1.Орон сууцны дэмжлэгийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан эсхүл дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдолд дэмжлэгийн мөнгийг буцаан төлүүлнэ.

6.2. Ажилтан, түүний эхнэр, нөхөр өмнө нь компаниас орон сууц, орон сууцны дэмжлэг авсан тохиолдолд орон сууцны хөнгөлөлт олгохгүй.

---o0o---